

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ТОГТООЛ2024 оны ... дугаар
сарын ны өдөр

Дугаар....

Улаанбаатар
хотХуулийг хэрэгжүүлэх зарим
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 487 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-ын нутгийн захиргааны байгууллагын “Удирдах” албан тушаалын “Ахлах түшмэл”-ийн ангиллын “ТЗ-4” зэрэглэлийн “9.Нийслэл, аймаг дахь Төрийн албаны Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга” гэсний дараа “10.Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дарга бөгөөд аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга” гэж, “Дэс түшмэл”-ийн ангиллын “ТЗ-6” зэрэглэлд “7.Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын хэлтсийн дарга” гэж, “ТЗ-8” зэрэглэлийн “4. ... хэлтсийн” гэсний өмнө “газар,” гэж тус тус нэмсүгэй.

2.“Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 487 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-ын төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа агентлаг, бусад байгууллагын “Удирдах” албан тушаалын “Эрхэлсэн түшмэл”-ийн ангиллын “ТЗ-3” зэрэглэлийн “5.Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын дарга” гэснийг “5.Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн дарга” гэж, “Ахлах түшмэл”-ийн ангиллын “ТЗ-4” зэрэглэлийн “6.Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын нарийн бичгийн дарга” гэснийг “6.Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн нарийн бичгийн дарга” гэж, “Гүйцэтгэх” албан тушаалын “Дэс түшмэл”-ийн ангиллын “ТЗ-7” зэрэглэлийн “7.Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын мэргэжилтэн” гэснийг “Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн мэргэжилтэн” гэж тус тус өөрчилсүгэй.

3.Засгийн газрын 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 4 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Засгийн газрын агентлагийн орон тооны хязгаар”-ын 14 дэх дугаарын Нийгмийн даатгалын ерөнхий газар “82” гэснийг “86” гэж өөрчилсүгэй.

4.Засгийн газрын “Агентлаг байгуулах тухай” 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 344 дүгээр тогтоолын 8 дахь заалтыг хүчингүй болгосугай.

5.Нийгмийн даатгалын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталж, шаардагдах зардлыг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад даалгасугай.

6.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 71 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ